

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

20... оны ... сарынөдөр

Дугаар

Улаанбаатар хот

Журам, маягт батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн албан татварын ногдуулалт, төлөлтийг шалгаж баталгаажуулах, татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт, түүний хавсралт"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчтэй харилцах, аймаг, нийслэл, дүүргийн татварын / газар, нэгж/ хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Татварын хяналт шалгалт, арга зүйн газар /О.Тэнгис/, Татварын орлогын газар /Д.Цогтжаргал/ -т тус тус үүрэг болгосугай.

3. Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн А/150 тоот тушаалаар батлагдсан "Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг шалгаж баталгаажуулах, гааль, татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэл хөтлөх журам"-ыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР СУУТГАН ТӨЛӨГЧИЙН
АЛБАН ТАТВАРЫН НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТИЙГ ШАЛГАЖ
БАТАЛГААЖУУЛАХ, ТАТВАРЫН БҮРТГЭЛ,
МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНД
БҮРТГЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нэмэгдсэн өртгийн албан татвар /цаашид “албан татвар” гэх/ суутган төлөгчийн хүсэлтээр эсхүл иж бүрэн хяналт шалгалт хийх үед нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн ногдуулалт, төлөлтийг шалгаж баталгаажуулах, татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Энэхүү журам нь Татварын ерөнхий хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, нягтлан бодох бүртгэлд тусгах журам” болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад актаас бүрдэнэ.

**Хоёр. Албан татварын ногдуулалт, төлөлтийг
баталгаажуулах шалгалт хийх**

2.1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, шалгагдсан хугацааны албан татварын үлдэгдлийг баталгаажуулан "Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт"-ыг үйлдэнэ.

2.2.Энэ журмын 2.1 дэх хэсэгт заасан акт нь нэгдсэн дугаартай үнэт цаас байх ба татварын албаны хяналт шалгалтын ажил эрхэлсэн нэгж /цаашид “ТХШАХН” гэх/-ийн татварын улсын (ахлах) байцаагчид “Татварын удирдлагын нэгдсэн систем”-д дугаарыг бүртгэнэ.

2.3.“Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан тооцоо”-ХШ-12 маягт нь "Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт"-ын салшгүй хэсэг болно.

2.4.Албан татварын илүү төлөлтийг баталгаажуулах шалгалтыг өмнөх шалгалтаар баталгаажуулсан үлдэгдлээс хойшхи тайлангийн хугацааны баримтад тулгуурлан хийх ба өмнө нь шалгалт хийгдэж "Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт", "Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан тооцоо"-ХШ-12 маягт үйлдээгүй тохиолдолд тухайн этгээдийн нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч болсон өдрөөс хойшхи хугацааны албан татвар ногдуулалт төлөлтийг шалгана.

2.5.Нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчийн албан татварын ногдуулалт, төлөлтийг шалгаж баталгаажуулаагүй нөхцөлд илүү төлсөн албан

татварын үлдэгдлийг буцаан олгох, бусад төрлийн татварын өрөнд суутган тооцох эрх үүсэхгүй.

2.6. "Нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчийн ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт"-ыг албан татвар суутган төлөгч нь эс зөвшөөрч Татварын маргаан таслах зөвлөл, шүүх, холбогдох хууль хяналтын байгууллагад хандсан тохиолдолд уг маргааныг эцэслэн шийдвэрлэгдсэний дараа дараагийн хугацааны албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хяналт шалгалтыг хийнэ.

2.7. Татвар төлөгчийн үйл ажиллагаанд хийх иж бүрэн шалгалтаар шалгагдаж буй хугацааны эцэст байгаа албан татварын үлдэгдлийг баталгаажуулан "Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан тооцоо"-ХШ-12 маягтыг үйлдэх бөгөөд энэ нь тухайн иж бүрэн шалгалтын үр дүнгээр гарах нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудасны хавсралт болно.

2.8. ТХШАХНэгжид татвар төлөгчийн үйл ажиллагаанд иж бүрэн хяналт шалгалт хийх явцад татвар төлөгч албан татварын илүү төлөлтөө буцаан авах, бусад татварын өрөнд суутгуулах хүсэлт гаргасан тохиолдолд хэсэгчилсэн шалгалтаар давхар томилолт үүсгэн шалгаж, "Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт"-ийг энэхүү журмын дагуу үйлдэнэ.

Гурав. Албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах ажлын явц, үр дүнг бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх

3.1. Албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах шалгалтыг аймаг, нийслэл, дүүрэг, Том татвар төлөгчтэй харилцах нэгжийн хяналт шалгалтын ажил эрхэлсэн нэгжид хийж, үр дүнг татварын эрсдэлийн удирдлага, хяналт шалгалтын "Татварын удирдлагын нэгдсэн систем"-д бүртгэхдээ илрүүлсэн зөрчлийн дүнг ХШ-6(1) маягтын илрүүлсэн зөрчил хэсэгт, бууруулсан албан татварын хэмжээгээр ХШ-6(2) маягтад ногдол үүсгэх, татвар төлөгчийн илүү төлөлтийг нэмэгдүүлэх нөхцөлд ХШ-6(2) маягтын буцаан олгох гэсэн хэсэгт нэмэгдүүлсэн татварын дүнг бүртгэнэ.

3.2. Аймаг, нийслэл, дүүргийн татварын албад нь татвар төлөгчийн хүсэлт, буцаан олгох татварын дүн саналыг Том татвар төлөгчтэй харилцах нэгжид ирүүлнэ. Харьяа нэгж дээр үүссэн хяналт шалгалтын ногдол татварын өрийн тооцоололд татагдахгүй.

3.3. Том татвар төлөгчтэй харилцах нэгжийн ТХШАХН нь аймаг, нийслэл, дүүргийн татварын албадаас ирүүлсэн саналыг хянаж баталгаажуулан нэмж илрүүлсэн зөрчлийн дүн, түүнд ногдох албан татварын дүнгээр ХШ-6(1), ХШ-6(2) маягтыг програмд бүртгэж нөхөн ногдол үүсгэнэ.

3.4. Хяналт шалгалтаар үүссэн нөхөн ногдлоор татвар төлөгчийн илүү төлөлт "Тэг" болсон эсхүл дутуу төлөлттэй болсон нөхцөлд хяналт шалгалтын ногдол нь татварын өрийн тооцоололд татагдан, тайлангийн илүү төлөлт болон хяналт шалгалтын ногдол хооронд хийгдэх суутган тооцооллыг харьяа албадын орлогын асуудал эрхэлсэн нэгжийн татварын улсын (ахлах) байцаагч хийнэ.

3.5. Том татвар төлөгчтэй харилцах нэгжийн "Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт"-ыг үндэслэн харьяа татварын албадын татварын орлогын асуудал эрхэлсэн нэгж нь хяналт шалгалтын нөхөн татварын өрийг тайлангийн илүү төлөлтөөс суутган тооцоолол хийнэ.

3.6. Том татвар төлөгчтэй харилцах нэгжийн ТХШАХН нь актыг энэ журамд заасан холбогдох хавсралтын хамт 4 хувь үйлдэх бөгөөд, хувь тус бүрийг дор дурдсан байгууллага, татвар төлөгч, нэгжид хүргүүлнэ.

3.6.1.Татвар төлөгч;

3.6.2.Харилцагч татварын албаны Татварын орлогын асуудал эрхэлсэн нэгж;

3.6.3.Хяналт шалгалтын хэлтсийн архивын материалд;

3.6.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага.

3.7. Том татвар төлөгчтэй харилцах нэгж нь "Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт"-ыг татвар төлөгчид гардуулсан өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан харилцагч татварын албанд хувийг хүргүүлнэ.

3.8.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн мэдээ, ТЕГ-ын Татварын орлогын асуудал эрхэлсэн нэгж төсвийн дансны хуулгыг үндэслэн харьяа албадын орлогын асуудал эрхэлсэн нэгжийн татварын улсын (ахлах) байцаагч нь Татварын тооцооллын програмын буцаан олголт оруулах дэд цэсээр буцаан олгох болон бусад төрлийн татварын өрөнд суутгасан бичилтийг бүртгэнэ.

3.9.Харьяа нэгжийн хийсэн иж бүрэн шалгалтын үр дүнгээр суутган төлөгчийн нэмэгдсэн өртгийн албан татвар илүү төлөлтийг бууруулж, хяналт шалгалтаар ногдол үүссэн нөхцөлд тайлангийн илүү төлөлт болон хяналт шалгалтын ногдол хооронд хийгдэх суутган тооцооллыг харьяа албадын орлогын асуудал эрхэлсэн нэгжийн татварын улсын (ахлах) байцаагч хийнэ.

Дөрөв. Албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах шалгалтанд тавигдах шаардлага

4.1.Шалгагдаж буй татвар суутган төлөгчийн худалдан авалт, түүнд төлсөн албан татвар нь "Нэмэгдсэн өртгийн албан татварын падаан", төлбөрийн баримт олгогдсон цахим төлбөрийн системд баталгаажсан байна.

4.2.Энэ журмын 4.1 дэх хэсэгт заасан үзүүлэлтүүдийг актын 2 дугаар хавсралтын 4 дэх хэсгийн VI баганад дэлгэрэнгүй тусгана.

4.3.Импортын бараанд төлсөн албан татварын дүнг гаалийн мэдээ, гаалийн бүрдүүлэлтийн баримтыг үндэслэн тодорхойлно.

4.4.Шалгагдаж буй тайлант хугацааны албан татварын тайлангийн үзүүлэлтүүдийг бусад төрлийн татварын тайлангуудын болон татварын мэдээллийн бааз дахь зохих үзүүлэлтүүдтэй тулган, нөлөөллийг тодорхойлж, илэрсэн зөрчлийг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.

4.5.Албан татвар суутган төлөгч нь үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар импортоор оруулсан болон худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний зарим хэсгийг албан татвар ногдох, үлдсэн хэсгийг албан татвараас чөлөөлөгдөх орлого олоход, эсхүл албан татвар ногдох орлого олоход хамааралгүй үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулсан тохиолдолд түүний худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоог Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгах журам"-д заасны дагуу хийнэ.

4.6."Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт"-ыг санхүү татварын тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны болон бусад баримт, холбогдох мэдээллийг үндэслэн үйлдэнэ.

4.7.Нэмэгдсэн өртгийн албан татварын илүү төлөлтийг баталгаажуулах хяналт шалгалт хийх явцад зөрчил илэрч татварын нөхөн ногдуулалт хийх бол нөхөн ногдуулалтын акт үйлдэнэ.

---oOo---